



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Дэд ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2022 оны 53 дугаар тушаалын 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагуудыг “Буянт Ухаа Олон улсын нисэх буудал”-ын Зорчигч үйлчилгээний барилгад шилжүүлэхтэй холбоотойгоор тус барилгын зориулалт өөрчлөх, технологийн шийдэл гаргах чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ахлагч:

Ц.Амарсанаа

Барилгын хөгжлийн төвийн захирал;
(Зөвшилцсөнөөр)

Гишүүд:

Б.Ганбат

Цахим хөгжил, Харилцаа холбооны сайдын зөвлөх; (Зөвшилцсөнөөр)

Ч.Отгон

ЦХХХЯ-ны Харилцаа холбоо, гамшгийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн;

Б.Төрбат

ЦХХХЯ-ны Техник хангамж, сүлжээ хариуцсан мэргэжилтэн;

Г.Лувсан-Одсэр

Зам тээврийн хөгжлийн яам Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын мэргэжилтэн; (Зөвшилцсөнөөр)

Л.Отгонжаргал

Буянт-Ухаа нисэх буудлын дарга;
(Зөвшилцсөнөөр)

Г.Мөнхболд

Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүйн ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Аеродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн дарга; (Зөвшилцсөнөөр)

ТӨБЗГ тушаал-/2022


132003353

М.Баттулга	Үндэсний дата төвийн захирал; (Зөвшилцсөнөөр)
О.Одбаяр	Барилгын хөгжлийн төвийн Хот байгуулалт төслийн институтийн эрхлэгч; (Зөвшилцсөнөөр)
Д.Алтанхуяг	Барилгын хөгжлийн төвийн Норм, нормативын хэлтсийн дарга; (Зөвшилцсөнөөр)
Б.Мөнхбаатар	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн;
М.Баярмаа	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн;
Н.Наранбаатар	Мэдээлэл холбооны сүлжээ Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэл чанарын хэлтсийн дарга; (Зөвшилцсөнөөр)
Нарийн бичиг: Д.Цэрэнпүрэв	ЦХХХЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн.

2. Дэд ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Удирдамжид заасан ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Дэд ажил хэсэг /Ц.Амарсанаа/-т, хэрэгжилтийг тухай бүр хянаж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ч.Золбаяр/-д тус тус даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Төрийн өмчийн бодолго, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 09 дугаар сарын
26 өдрийн 1/36 дугаар тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

1. Зорилго

Барилга архитектурын болон инженерийн хангамжийн шугам сүлжээний оновчтой шийдэл бүхий барилгын ажлын зургийн даалгавар боловсруулах, түүнтэй холбоотой санал дүгнэлт гаргахад энэхүү Дэд ажлын хэсгийн үйл ажиллагааны зорилго оршино.

2. Хугацаа

Дэд ажлын хэсэг ажиллах хугацаа 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийг дуустал байна.

3. Хамрах хүрээ

“Буянт Ухаа Олон улсын нисэх буудал”-ын Зорчигч үйлчилгээний барилга, гадна зам талбайн тохижилт, инженерийн дэд бүтэц хамаарна

4. Санал, дүгнэлт гаргах чиглэл

Дэд ажлын хэсэг дараах чиглэлээр санал, дүгнэлт гаргана:

- 4.1. Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын зориулалтыг хэсэгчилж өөрчлөх барилгын ажлын зургийн даалгавар боловсруулж, холбогдох санхүүжилтийн тооцоог гаргаж, батлуулах;
- 4.2. Зураг төсөл боловсруулах хуулийн этгээдийг зохих журмын дагуу сонгон шалгаруулах;
- 4.3. Бусад байгууллагын зайлшгүй оролцох инженер техникийн ажилтнуудтай хамтран нэмэлт техникийн шаардлагыг тодорхойлох, боловсруулах, батлуулах;

5. Хүрэх үр дүн

- 5.1. Холбогдох санал, дүгнэлтээ боловсруулж, Ажлын хэсэгт танилцуулсан байна.
- 5.2. Дэд ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн ЦХХХЯ, түүний харьяа болон салбарын байгууллагуудыг нүүлгэх ажлын үе шат, хуваарийг тодорхойлно.

---ooOoo---